

Б.ЭРДЭНЭ-ОЧИР

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн багши, ахмад



М.АБАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 531 дүгээр дамжааны сонсогч



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимээс гадаад орнуудын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас цуврал болгон товчлон орчуулж байна. Энэ удаа Казахстан улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиас шийдвэр гүйцэтгэгчийн эрх үүрэг, сонгон шалгаруулалт хэрхэн явагддаг талаар товчлон хургуулж байна.

КАЗАХСТАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИАС

Казахстан улсын Шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль 1998.04.30-нд батлагдсан. Нийт 5 бүлэг, 17 зүйл, 175 заалттай.

16 дугаар зүйл

Казакстан улсын хувийн шийдвэр гүйцэтгэгчид:

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалд 25 нас хүрсэн, дээд боловсролтой, хуульч мэргэжилтэй, хувийн шийдвэр гүйцэтгэлийн албанад доод тал нь 1

жил тасралтгүй ажилласан, сонгон шалгаруулалтанд тэнцсэн, хувийн шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн, гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулах талаар хөдөлмөр эрхлэх эрхийн гэрчилгээ авсан, энэ хуулинд заасан журмын дагуу хувийн шийдвэр гүйцэтгэх албаны сул орон тоонд шалгалт өгч тэнцсэн Казакстан улсын иргэнийг томилно.

2. Хуульд заасан журмын дагуу тэнцээгүй, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах мэдлэггүй ба үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарласан, шүүхийн шийдвэрээр бусдад төлөх төлбөртэй хүн хувийн шийдвэр гүйцэтгэгч болох боломжгүй. Өөрөө цагаатгах боломжгүй гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон ба хувийн шийдвэр гүйцэтгэгч хөдөлмөр эрхлэх гэрчилгээ нь хүчингүй болсон хүн хувийн шийдвэр гүйцэтгэгч болохыг хориглоно.

3. Хувийн шийдвэр гүйцэтгэгч тэтгэврийн насанд хүртэл өөрийн хөдөлмөрийг эрхлэх эрхтэй. Хувийн шийдвэр гүйцэтгэгч тэтгэвэрийн насанд хүрсэний дараа өөрийнхөө үүргийг хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын холбооны саналыг үндэслэн авч, зөвхөн төлөөлөгчийн газрын зөвшөөрлөөр тэтгэвэрийн насанд хүрсэний дараа дээд тал нь 5 жил хүртэл хугацаанд ажиллах эрхтэй.

4. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн, журмын төлөөлөгчийн газар болон хувийн шийдвэр гүйцэтгэгчийн холбооны тохиролцсоны үндсэн дээр хувийн шийдвэр гүйцэтгэгчийг томилно.

5. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн албаны үүргийг нэр төртэй, хариуцлагатайгаар гүйцэтгэнэ. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь хуулийн этгээд тул

Казахстан улсын татварын хуулинд заасан журмын дагуу улсад тодорхой хэмжээний татвар төлнө.

142 дугаар заалт Гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх тухай ажиллагааг явуулах эрхийн гэрчилгээ

1. Шийдвэр гүйцэтгэгчийн эрхийн гэрчилгээ авсан хувийн шийдвэр гүйцэтгэгч нь хуулийн хүрээнд гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхтэй.
2. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг ур чадварын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн төлөөлөгчийн газар олгоно. Төлөөлөгчийн газар нь гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх тухай ажиллагааг явуулах эрхийн гэрчилгээг улсын бүртгэлээр явуулна. Төлөөлөгчийн газар нь гэрчилгээ олгохоос татгалзсан нөхцөлд шийдвэрийг гардаж авсан өдрөөс эхлэн 15 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.
3. Ур чадварын шалгалтанд бүрдүүлэх шаардлагтай материал, баримт бичгийн жагсаалтыг төлөөлөгчийн газар, хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын холбооны тохиролцсоноор баталж ур чадварын шалгалтын тухай дүрэм баталж тэмдэглэнэ. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээ олгох хугацаа ба журам нь Казакстан улсын гэрчилгээ олгох тухай хуулийн хүрээнд явагдана.
4. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг төлбөртэй олгоно. Уг төлбөрийн хэмжээ ба журмыг Казакстан улсын татварын тухай хуулиар тодорхойлно.
5. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг хугацаагүй олгох бөгөөд уг гэрчилгээ нь ерөнхий гэрчилгээ байна. Ерөнхий гэрчилгээ нь Казакстан улсын нийт нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилнэ.

6. Ерөнхий гэрчилгээг авсан боловч шийдвэр гүйцэтгэлийн албандаа 3 жил хүртэл хугацаанд ажиллаагүй бол ур чадварын шалгалт давтан өгсөний дараа шийдвэр гүйцэтгэгчийн албандаа ажиллах эрх нь үүснэ. Ур чадварын шалгалтыг давтан өгсөний төлөө төлбөр авахгүй. Дээрхи хугацааг тооцоходоо уг хүний хувийн шийдвэр гүйцэтгэгчийн туслахаар ажилласан хугацааг оруулан тооцохгүй.

7. Хууль зөрчсөний төлөө шүүгчийн албанаас чөлөөлөгдсөн шүүгч, төлөөлөгчийн газар ба түүний тойргийн бүрэлдэхүүнд зөрчлийн улмаас чөлөөлөгдсөнөөс хойш 5 жил өнгөрөөгүй иргэдээс бусад шүүх, прокурорын системд 10-аас доошгүй жил ажилласан шүүгч, прокурор шалгалтанд орохгүйгээр шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг шууд авах эрхтэй.

143 дугаар зүйл Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн түр түдгэлзүүлэх үндэслэл

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг түр түдгэлзүүлэхдээ сахилгын хорооны шийдвэрийг үндэслэн төлөөлөгчийн газрын өргөдөлийн дагуу шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлнэ.
2. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг түдгэлзүүлэх үндэслэлүүд:
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь эрүүгийн хэрэгт сэжигтийн татагдсан
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажиллагаа явуулах үед Казакстан улсын хуулийг ноцтой зөрчсөн
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийнхөө хуулиар тогтоосон тойргоос бусад тойрогт гүйцэтгэх ажиллагаа явуулсан.
3. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг ашиглахыг түдгэлзүүлэх тухай шүүхийн

шийдвэрт түдгэлзүүлсэн үндэслэл ба хугацааг тодорхой заана. Түр түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хувийн шийдвэр гүйцэтгэгч үйл ажиллагаа явуулах эрх нь түр хугацаагаар зогсоно. Түр түдгэлзүүлэх үндэслэлүүд арилсан нөхцөлд төлөөлөгчийн газраас шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах эрхийг нь олгоно.

4. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх тухай шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн хувийн шийдвэр гүйцэтгэгчийн хувьд үүрэг гүйцэтгэгч болно.

144 дугаар зүйл

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг зогсоох

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг цушлах ерөнхий үндэслэл.

- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахдаа улс олон нийт, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулж, Казакстан улсын хуулийг ноцтой зөрчсөн.
- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түр түдгэлзүүлсэн үндэслэлүүд арилаагүй
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг авахын тулд шаардлагтай баримт бичгүүдийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон
- Ур чадварын зөвлөл дахин аттестачилсан дүнгийн дагуу хувийн шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаанд тэнцэхгүй гэж заасан.
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн ажиллагааг тодорхой үндэслэл, шалтгаангүйгээр 3 хүртэл хоногоор явуулаагүй.

- Эрүүл мэндийн байдлаас болон албаны үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон нь шүүхээр тогтоогдсон.
- 2. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг зогсоох ерөнхий үндэслэлээс бусад тохиолдолууд:
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгч өөрөө өргөдөл гаргасан
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн иргэний харьяа нь өөрчлөгдсөн эсвэл Казакстан улсаас гадна улс оронд суурьших болсон
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон
 - Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь нас барсан эсвэл сураггүй алга болсонд тооцогдож зарлагдсан нөхцөлд зогсоно.
- 3. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гэрчилгээ ашиглахыг зогсоох тухай хүсэлтээ төлөөлөгчийн газарт, прокурорт, хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын ёс зүйн зөвлөлд эсвэл тойргийн албанд гаргана.
- 4. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын зөвлөл төлөөлөгчийн газрын даалгаврын дагуу гэрчилгээ ашиглахыг зогсоох ба шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулах, түүнчлэн хүчингүй болсон хувийн шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээ, тэмдэгийг төлөөлөгчийн газарт хүлээлгэн өгч устгуулах арга хэмжээ авна. Банк ба банк бус санхүүгийн байгууллага гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийн газрын даргын тушаалыг үндэслэн ажиллагааны зардлын данс, тайлан тооцоог шинээр томилогдсон хувийн шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.
- 5. Хэрвээ хувийн шийдвэр гүйцэтгэгчид хамаатай захиргааны зөрчил үүссэн бол уг зөрчлийн арга хэмжээ дууссаны дараа төлөөлөгчийн газраас албанаас чөлөөлнө.

6. Хувийн шийдвэр гүйцэтгэгч төлөөлөгчийн газрын шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

147-Р ЗҮЙЛ

Хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын эрх үүрэг ба хариуцлага

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн ажиллагаа хийлгүүлэх хүсэлт гаргасан иргэн болон хуулийн этгээдийн боломжоор хангах

2. Дурын банк ба Банк санхүүгийн түүний дотор валютын данс нээх, үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгийн хураах, ажилтан албан хаагчдад мэдэгдэл гардуулах, хөлслөх, шүүхийн шийдвэрийн дагуу ажлаас нь чөлөөлөх, цалингийн суутгал хийх, шүүхэд тайлбар гаргах, Казакстан улсын хуульд нийцсэн бусад аргуудыг хэрэглэх

3. Казакстан улсын хуулинд заасны дагуу улсын нийгэм, эрүүл мэнд, нийгэм хамгааллын системийн бүх хөнгөлөлт эдлэх

4. Төлбөр төлөгчтэй холбоотой бүх мэдээллийг улсын болон хувийн байгууллагуудаас өмчийн хэлбэр харгалзахгүй албадан гаргуулах

5. Казахстан улсын хууль эрхийн актуудад заасан бусад эрхийг эдлэх эрхтэй.

148-Р ЗҮЙЛ

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үүрэг

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн албанд томилогдонон дараа бүртгүүлэхийн тулд ажлын 3 хоногийн дотор татварын албанд өргөдөл гаргах

2. Уг хууль ба Казахстан улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дотоод журам бусад нарийвчилсан эрх зүйн актанд нийцсэн гүйцэтгэлийн ажиллагаа явуулах

3. Өөрийн албан үүргээ шударгаар гүйцэтгэх, гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад өөрт нь тодорхой болсон төрийн болон хувийн нууцыг задруулахгүй, чандлан сахих үүрэгтэй.

4. Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц үйл ажиллагаа явуулсан өдрөөс эхлэн 24 цагийн дотор хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын зөвлөлд мэдэгдэх

5. Албаны ёс зүйг сахих

6. Албаны өрөөтэй байх

7. Хувийн шийдвэр гүйцэтгэгч ажлын тайлангаа долоо хоног, сар, улирал, хагас жил, жилээр нь гаргаж, гүйцэтгэсэн арга, шаардлагтай баримт бичгийн хуулбарын хамт хувийн шийдвэр гүйцэтгэлийн холбоонд явуулж байна.

8. Төлбөр төлөгчийн хууль бус үйлдэл талаар үндэслэлтэй гэж үзвэл тойргийн хэлтэст холбогдох материалыг бүрдүүлж явуулах

9. Өөрийн албаны ур чадварыг байнга нэмэгдүүлж байх

10. Казакстан улсын хууль эрх зүйн актанд заасан бусад үүргийг хүлээнэ

149 дүгээр зүйл

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлыг хязгаарлах

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгч эрдэм шинжилгээний, багшлах, эсвэл зохиолчийн хөдөлмөрөөс бусад ажлыг эрхлэх эрхгүй.

150 дугаар заалт

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн хариуцлага

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгч өөртөө оногдсон албаны үүргээ үл биелүүлбэл Казакстан улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

2. Хувийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа өөрийн

буруутай үйлдэл, эс үйлдэлээс бусдад хохирол учруулсан бол Казахстан улсын хуульд заасны дагуу учирсан хохирлыг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

“ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СТАТИСТИК” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦЛОО



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процесийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа Б.Алтангэрэл, ахлах багш, ахмад О.Батсайхан, Ахлагчийн сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн ахлах багш, хошууч Н.Батдорж нар 2013 оны 09 дүгээр сарын 13-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотод зохион байгуулагдсан “Эрүүгийн эрх зүйн социологи: Эрүүгийн эрх зүйн статистик” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцлоо. Тус олон улсын эрдэм шинжилгээний хуралд ОХУ, Украян, Казакстан, Монгол, Буриад улсын төлөөлөгч нар оролцож илтгэл хэлэлцүүллээ.

Олон улсын эрдэм шинжилгээний хурал 09 дүгээр сарын 13-ны 09.30-17.00 минутад Улаан-Үдийн төр, захиргааны төв байрны хурлын зааланд эхэлж доорхи үндсэн илтгэлүүдийг авч хэлэлцсэн. Үүнд:

1. Скуратов Юрий Ильич, 21 дүгээр зууны эрх зүйн технологи сангийн